

МОНГОЛ ДАХЬ ХҮМҮҮН КАПИТАЛ

Б. Болдбаатар¹

JEL ангилал:

A10, E02, E50,
E60, G21, G23, J24

Түлхүүр үгс:

Хүмүүн капитал,
хүний хөгжлийн
индекс, үндэсний
баялаг, тогтвортой
хөгжил

Хураангуй:

Энэхүү өгүүлэлд хүмүүн капитал хэрхэн бүрэлдэн бий болж, хэрхэн үйлчилж байгаа байдал, тэдгээрийн уялдаа холбоо, хүний хөгжилд нөлөөлж буй хүчин зүйл, нөхцөлүүдийг судлахын ач холбогдлыг тодорхойлж, хүмүүн капитал нь үндэсний баялгийн нэгэн гол хэсэг болохыг дурдаад цаашид хүмүүн капиталын асуудлыг тогтвортой хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогод тусгах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийжээ.

1. Хүмүүн капиталын онолын асуудал

Хүн төрөлхтний хөгжлийн түүхээс харахад, хөгжлийн ямар нэгэн тогтсон нийтлэг загвар байдаггүй аж. Улс орон бүр өөрийн түүх, соёл, иргэншил, улс төр, нийгмийн уламжлалд тулгуурласан өөрийн замаар явдаг хэдий ч дэлхийн соёл иргэншлийн агуу их өв уламжлал, туршлагыг харгалзан үзэх учиртай. Тийм ч учраас хөгжингүй орнуудад хүмүүн капитал хэрхэн бүрэлдэн бий болж, хэрхэн үйлчилж байгаа байдал, тэдгээрийн уялдаа холбоо, хүний хөгжилд нөлөөлж буй хүчин зүйл, нөхцөлүүдийг судалснаар орчин үеийн эдийн засгийн ухааны ололт амжилт, туршлагыг манай оронд ашиглах, зарим нэгэн сөрөг үзэгдлийг тойрон гарах боломж бүрдэнэ.

Мэдээж хэрэг, ардчиллын замаар хэдэн зуун жил хөгжсөн орнуудын хөдөлмөрийн зах зээл, хүмүүн капиталын зохицуулалт нь зах зээлийн жамаар төлөвшсөн эдийн засгийн онол, арга зүй дээр тулгуурласан байдаг бол манай оронд зах зээлийн эдийн засгийн төлөвшил нь нийгэм, улс төр, эдийн засгийн тэс өөр нөхцөл байдалд явагдаж байгаа боловч манай орны нийгэм, эдийн засгийн үндэсний хөгжлийн загвар нь бусдаас өөр байна гэсэн үг биш юм. Харин ардчилсан засаглалтай орон бүрийн үндэсний хөгжлийн загвар нь эдийн засгийн нийтлэг хуулиуд болон хувь хүний эдийн засгийн шийдэл, үйл хөдлөл,

¹ Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, ОХУ-ын Эрхүү хотын Байгалийн улсын их сургуулийн профессор. Цахим шуудан: msbjournal@yahoo.com

хүний хөгжлийн үндсэн зарчмуудад тулгуурладаг гэдгийг л бид байнга санаж, бодож байх учиртай.

Сүүлийн жилүүдэд манай оронд ядуурал, ажилгүйдлийн түвшин дорвитой буурахгүй, баялгийг хүртэх ялгаа эрс нэмэгдэж байгаа нь нийгмийн хөгжлийн асуудлыг хурцатгаж байгаа бөгөөд зөвхөн хүн амын амьжиргааны түвшинг бууруулаад зогсохгүй, манай нийгмийн эдийн засгийн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүйд хүргэж байгаа юм. Тулгараад буй санхүү, эдийн засгийн хямрал нь хүний хөгжлийг сааруулах, хүн амын орлого багасах, амьдралын чанар буурах, улмаар нийгэмд баян, хоосны ялгаа улам бүр ихсэхэд нөлөөлж буй учраас хүний хөгжил, хүмүүн капиталын асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлага амьдралаас урган гарч байна.

XX зууны 80-аад оны эхнээс мэдээллийн хувьсгалын үе эхэлж, хүн төрөлхтөн хөгжлийн дараагийн шат – мэдээллийн эринд шилжсэнээр, хүн амын боловсролын түвшин болон нийгмийн хуримтлуулсан мэдлэгийн хэмжээ бүхнийг шийдвэрлэх болжээ. Эдийн засгийн өсөлт, хүний хөгжил, амьдралын чанар дээшлэхийн эх булаг, учиг үндэс нь материаллаг болон байгалийн баялагт тулгуурлаж байсан бол аажмаар нийгэмд хуримтлагдсан мэдлэг, мэдээллийн нөөцөд, өөрөөр хэлбэл хүмүүн капиталд тулгуурлах боллоо.

Зах зээлийн эдийн засаг бүрэлдэн тогтох үед, *нэг талаас*, материаллаг баялгийг бүтээдэг, *нөгөө талаас*, энэхүү баялгийг хэрэглэдэг хувь хүн нь нийгэм, эдийн засгийн өсөлтөд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг болж байна.

Манай орны нийгэм, эдийн засгийн цаашдын хөгжил нь “мэдлэгт суурилсан” эдийн засгийн хөгжлийн гол хүчин зүйл болсон хувь хүний бүтээн байгуулах авьяас чадвар, чадавхыг хэрхэн хөгжүүлэхээс шууд хамаарна. Тухайн нийгмийн үндэсний баялгийн үндсэн хэсэг нь хүмүүн капитал мөн. Энэ өнцгөөс хувь хүн өөрийн бүтээн байгуулах авьяас чадвар, чадавх, түүнд оруулж буй хөрөнгө оруулалтыг ашиглан өөрийгөө болон хүрээлэн буй орчныг хэрхэн өөрчлөн шинэчилж байгааг судлах нь орчин цагийн шинжлэх ухааны нэгэн гол асуудал болсон ажээ. Ийм ч учраас нэгэнт бүрэлдсэн хүмүүн капиталыг үр дүнтэй ашиглах, цаашид хөгжүүлэх боломжийг эрж хайх, мөн бүрэн дүүрэн ашиглах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, онол, арга зүйн эрэл хайгуул хийх зайлшгүй шаардлага бий болж байна.

Өнгөрсөн зууны 60-аад оны эхээр америкийн эрдэмтэн, Нобелийн шагналт Т.Щульц, Г.Беккер нар нь зах зээлийн эдийн засгийн ухаанд хүмүүн капиталын онолын үзэл баримтлалыг боловсруулах эхлэлийг тавьсан гэдэг хэдий ч түүнээс урьд “хүмүүн капитал”-ын онолын үндэс нь английн эдийн засагч А.Смит, У.Петти, Д.Рикардо, зөвлөлтийн эрдэмтэн С.Г.Струмилин нарын суурь бүтээлүүдэд тусгалаа олсон байжээ.

Тэд хувь хүн, түүний авъяас чадварыг “капитал” хэмээн үзэж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, нэмэгдэл орлого олохын тулд хувь хүнд чиглэсэн хөрөнгө оруулалтын ач холбогдлыг өндрөөр үнэлж байсан юм.

Английн сонгодог эдийн засгийн онолын эцэг хэмээгдэх У.Пэтти 1664 онд бичихдээ: *“тухайн орны нэр хүнд нь түүний хүн амын тоо, ард түмний авъяас чадвар, хичээнгүй хөдөлмөр² дээр тогтдог гээд улс орны үндсэн баялаг нь хөдөлмөрлөх, хийж бүтээх чадавхтай хүмүүс мөн”* гэжээ. У.Пэттигийн бүтээлүүдэд хүмүүсийн хөдөлмөрийн чанарыг үнэлэх гол үзэл баримтлал, арга зам тусгалаа олжээ. Гэхдээ хувь хүнд зарцуулсан хөрөнгө, эрхэлж буй ажил бүр үр ашигтай байж чаддаггүй, улс орны баялгийг нэмэгдүүлдэггүй гэсэн түүний дүгнэлт нь өнөөг хүртэл ач холбогдлоо алдаагүй л байна.

Нэрт эдийн засагч А.Смит XVIII зуунд бичихдээ: *“ашигтай хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх нь юуны түрүүнд ажилчны авъяас чадвар, мэргэжлийг дээшлүүлэхээс хамаарах бөгөөд дараа нь түүний ажиллаж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг сайжруулахаас хамаарна”³* гэжээ.

Үндсэн хөрөнгө нь тоног төхөөрөмж, хөдөлмөрийн бусад багаж хэрэгсэл, байшин барилга, газар болон *“нийгмийн бүх гишүүдийн төрөлхийн авъяас чадвар, эзэмшсэн мэргэжил, чадавх”*-аас бүрэлдэнэ гэж А.Смит үзэж байсан. Цааш нь *“Ийм мэргэжил, чадавхыг эзэмшүүлэхийн тулд тухайн хүнийг хүмүүжүүлэх, мэргэжилд сургах, дагалдан сургах хугацаанд зарцуулсан бодит зардлыг хувь хүнд бий болсон үндсэн капитал гэж үзэж болно. Хэдийгээр өндөр зардлаар бий болсон ч гэсэн хөдөлмөрийг хөнгөвчилж, багасгаснаар өөрийн зардлыг нөхөөд ашигтай ажилладаг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй адилтгах өнцгөөс ажилчны мэргэжлийн өндөр ур чадвар, авъяасыг үнэлж болох юм”⁴* гэсэн байна.

А.Смитийн үзэл баримтлалыг Английн сонгодог эдийн засгийн онолын өөр нэгэн төлөөлөгч Д.Рикардо үргэлжлүүлсэн бөгөөд тэрээр хөлсөөр ажилладаг хүмүүсийг “ажиллах хүчин” гэж тодорхойлсон анхдагчийн нэг юм. Ард түмэн хөдөлмөрийн үр шимийг хүртэж, хүн ам өсөн үржиж байгааг тэрээр хувь хүний хөдөлмөрлөх чадварыг нөхөн үйлдвэрлэх явцтай адилтган ойлгож байсан. *“Ажилчин, түүний гэр бүлийг тэжээхэд шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн, өдөр тутмын хэрэглээний бараа, ойр зуурын хэрэглээний барааны үнэ буюу бодит цалингаас хамаардаг “хөдөлмөрийн жирийн үнэ цэн”-*

² Пэтти У. Экономические и статистические работы. – М.: 1940. – 17 дахь тал.

³ Смит А. Исследование о природе и причинах богатства народов (*An Inquiry into the Nature and Causes of the Wealth of Nations*), - М.: Соцэкгиз, 1962. – 490 дэх тал.

⁴ Смит А. Исследование о природе и причинах богатства народов (*An Inquiry into the Nature and Causes of the Wealth of Nations*), - М.: Соцэкгиз, 1962. – 208, 235 дахь тал.

ийн хэмжээ нь хэрэглээний түвшинд шууд нөлөөлдөг” хэмээн Д. Рикардо үзэж байсан ажээ⁵.

“Хувь хүнд чиглэсэн хөрөнгө оруулалтын зардал нь хөдөлмөрлөх боломжийг хангаж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхээс гадна ашиг олж, нөхөн төлөгддөг гэдгийг энд тэмдэглэх хэрэгтэй. Энэ үзэл санаа л хүмүүн капиталын орчин үеийн онолын суурь болдог юм”⁶ гэж оросын эрдэмтэн М.М.Критский үзэж байна.

Хэдийгээр хүмүүн капиталын онол нь хөгжингүй орнуудад нэлээд хөгжиж нийгмийн зүгээс дэмжлэг авч, суурь бүтээлүүд хэвлэгдэн зах зээлийн эдийн засгийн ухаанд бодит хувь нэмэр оруулж буй боловч одоогоор манай орны эдийн засгийн ухаанд хувь хүний бүтээн босгох чадварыг хэрхэн хөгжүүлэх, үр дүнтэй ашиглах асуудал чамлалттай судлагджээ гэж үзэж болно. Энэхүү асуудлыг судлахад юуны түрүүнд “хүний нөөц”, “ажиллах хүчин” гэсэн ойлголт давамгайлж, хүний үйлдвэрлэх чадавхыг эдийн засгийн талаас нь үнэлдэггүй байсан учраас капитал талаас нь судалдаггүй байсан ажээ.

Ажиллах хүчин бүрэлдэх, хүмүүн капитал бий болох асуудлыг хамтад нь авч үзэлгүй, тус тусад нь судлах нь бас л учир дутагдалтай. Хүний хөгжил, хүн амын амьдралын чанар нь хүмүүн капитал бий болоход хэрхэн нөлөөлж буй, мөн нэгэнт бий болсон хүмүүн капитал эргээд хүний хөгжил, хүн амын амьдралын чанарт хэрхэн нөлөөлж буйг цогц байдлаар судлах шаардлагатай байна. Нийгмийн бүлэг, давхарга бүрт хүмүүн капитал хэрхэн бий болж байгааг судалж, зах зээлийн эдийн засгийн үед бүрэлдэж буй хүмүүн капиталын чанарыг тал бүрээс нь үнэлэх шаардлага байгаа юм.

Хүний хөгжил, хүмүүн капитал гэдэг ойлголтыг салгаж ойлгох нь чухлаас гадна хувь хүн хөгжих явцад хүмүүн капитал бүрэлдэн бий болж буй үйл явцыг төрөөс хэрхэн зохицуулах асуудлыг нухацтай авч үзэх ёстой. Нийгэмд чиглэсэн зах зээлийг хөгжүүлж буй манай орны хувьд хүмүүн капиталыг бүрдүүлэх үндсэн суурь болж буй боловсрол, мэргэжлийн боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийн асуудлыг цогцоор нь, хүний хөгжлийн хүчин зүйл талаас нь авч үзэх хэрэгтэй.

Дээр өгүүлснээс үзэхэд, зах зээлийн харилцаа бүрэлдэн тогтож байгаа өнөө үед орчин үеийн эдийн засгийн онолыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой асуудалд яах аргагүй хүмүүн капиталын онол, арга зүйн асуудал хамаарна.

⁵ Рикардо Д. Сочинения. Б.1. – М.: 1955. 183х.

⁶ Критский М.М. Человеческий капитал. Л.: Изд-во ЛГУ, 1991. 65х.

Эдийн засгийн ухааны үүднээс үзэхэд, Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчин нь хүмүүн капиталд хэрхэн хувирч буй үйл явцын үндэслэл; үндэсний баялгийн үндсэн нэг хэсэг болох хүмүүн капитал хэрхэн бүрэлдэж, хэрхэн нөхөн үйлдвэрлэгдэж буй зарчмыг тодорхойлох; нэгэнт бий болсон хүмүүн капиталыг өгөөжтэй ашиглах замаар манай орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь хөгжлийн стратегийн тэргүүн зорилт болох учиртай.

АНУ, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас үзэхэд, хүний хүчин зүйл нь шинжлэх ухаан, технологийн болон эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийн гол хөдөлгөгч хүч болох хүртлээ тодорхой түүхэн замыг туулсан ажээ. Ерөнхий болон мэргэжлийн боловсролын тогтолцоог шинэчлэн сайжруулах нь энэхүү замын үндсэн чиглэл болох бөгөөд орчин үед улам ч илүү өндөр шаардлага тавигдах болсон ажээ.

Инноваци, өндөр технологийн үйлдвэрлэлд суурилсан эдийн засгийн өсөлтийн үед сайн чанарын, мэргэшсэн, нарийн мэргэжлийн ажиллах хүчнийг уламжлалт бус аргаар бэлтгэх зайлшгүй шаардлага тулгарч байна. *Нэгдүгээрт*, боловсролын салбар нь шинэ мэдлэг үйлдвэрлэх чадалтай хүмүүсийг олноор нь бэлтгэн гаргах шаардлагатай; *хоёрдугаарт*, мэргэжлийн боловсролын салбар нь бүтээмж сайтай ажилтан бэлтгэхээс гадна хувь хүний бизнес сэтгэлгээг, өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийг зохион байгуулах, өөрийн хөдөлмөрийг үр ашигтай зохицуулах шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх үүрэгтэй. Боловсролын салбарын үүрэг нь байгаа мэдлэг, ур чадварыг суралцагчдад зөвхөн автоматаар заахдаа бус хувь хүн энэхүү мэдлэг, чадвараа байнга дээшлүүлж байх сонирхлыг бий болгох, шинэ санаа сэдэл, техникийн шийдлийг хүлээн авч, өөрийн ажлын байранд зохицуулан хэрэглэх чадварыг дээшлүүлэхэд оршдог ажээ.

*“Хүмүүн капитал бол ирээдүйн орлого буюу ирээдүйн хангамжийн эх үүсвэр болдог учраас капиталын нэг хэлбэр мөн. Тэрээр хувь хүний нэгэн хэсэг болдог учраас хүмүүн капитал юм”*⁷ гэсэн америкийн эрдэмтэн Г.Боуэний тодорхойлолттой санал нийлэхээс өөр аргагүй юм. Ийм ч учраас “хүмүүн капитал” гэдэг нэр томъёо гарч ирсэн билээ.

Эдийн засаг, хөдөлмөрийн эдийн засаг, боловсролын эдийн засгийн чиглэлийн сурах бичгүүдэд хүмүүн капиталын сүүлийн үеийн тодорхойлолтыг дурдсан байна. Жишээлбэл, С.Фишер нарын эрдэмтэд хүмүүн капиталыг “*хувь хүний орлого олох чадварын хэмжээ*”⁸ гэсэн бол Д.Эренберг нарын эрдэмтэд

⁷ Bowen H.R. Investment in Learning. San Francisco, 1978, 362 тал

⁸ Фишер С., Дорнбуш Р. Шпалензи Р. Экономика. — М.: 1993, 303 тал

“ажил олгогч хөлсөлж авч болох хувь хүний үр чадварын нийлбэрийн материаллаг илэрхийлэл”, “үйлдвэрлэгч капиталын нөөц”⁹ хэмээн тодорхойлжээ.

Эдийн засагчдын үзэж буйгаар, боловсрол, мэргэжлийн сургалт, эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхэд төрүүлэх, түүнийг асрах зэрэг нь хүмүүн капиталыг бий болгож буй үндсэн хэлбэр юм. Боловсрол, мэргэжлийн сургалт нь хүний мэдлэгийн түвшинг дээшлүүлснээр хүмүүн капиталын хэмжээг өсгөдөг. Харин хувь хүний эрүүл мэндийг хамгаалах нь өвчлөлт, нас баралтыг багасгах замаар хүний үр ашигтай амьдралын хугацааг уртасгадаг. Хүүхэд төрүүлж, түүнийг өсгөн бойжуулах нь хүмүүн капиталын нөхөн үйлдвэрлэл юм.

Хүмүүн капиталын онолын төрөл бүрийн чиглэлээс янз бүрийн тодорхойлолт гаргадаг хэдий ч ихэнх судлаачид хүмүүн капиталыг: *нэг талаас*, чанартай ажилтан бэлтгэхэд зарцуулсан зардлын нийлбэр, өөрөөр хэлбэл, тодорхой хүнийг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх чадварыг хөгжүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалт; *нөгөө талаас*, олж авсан мэдлэг, дадлага, туршлага, мотиваци, тодорхой хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулахад шаардагдах эрч хүч зэргийн нийлбэр гэж үздэг.

Жишээлбэл, америкийн судлаач А.Стюарт бичихдээ: “*оюуны капитал гурван бүрэлдэхүүнтэй: хүмүүн капитал, бүтээн байгуулалтын капитал ба хэрэглээний капитал*” гэжээ. Түүний тодорхойлсноор “*Оюуны капитал нь мэдлэг, туршлага, мэдээлэл ба оюуны чадвар болон үнэт зүйлийг бүтээхэд оролцогч оюуны хөрөнгө бөгөөд энэ нь хамт олны оюуны энерги юм. Түүнийг мэдрэхэд хэцүү, удирдан залахад улам ч хэцүү, ийм ч учраас хүмүүн капитал их өндөр үнэлэгддэг боловч түүнийг тааруу удирдан чиглүүлдэг*” гэжээ.

Зохиогч миний үзэж байгаагаар: “*Хүмүүн капитал нь хүний төрөлхийн болон удамшсан авъяас чадвар, олж авсан мэдлэг, туршлага, орлого олох чадвар зэргийн нийлбэр*” юм.

Хүмүүн капиталын онол нь эхний ээлжинд хувь хүний оюуны болон хөдөлмөрлөх чадвар, үйлдвэрлэлийн явцад тухайн ажилтны хөдөлмөрийн үр дүнд бий болж буй орлогыг судалдаг.

Хүмүүн капиталд шууд хөрөнгө оруулах нь түүний багтаамжийг нэмэгдүүлдэг, шууд бус хөрөнгө оруулалт нь түүний “ашиглалт”-ын хугацааг уртасгаж, үйл ажиллагааны нөхцөлийг сайжруулан, өвчлөлт, нас баралтыг бууруулан үр өгөөжийг нэмэгдүүлдэг. Гэхдээ хөрөнгө оруулалтыг биет хөрөнгө ба хүмүүн капиталын алинд нь оруулж байгаагийн бодит ялгааг бид ойлгох хэрэгтэй. Бодит ялгаа нь гэвэл биет хөрөнгөд тэнцүү хөрөнгө оруулалт хийхэд

⁹ Эренберг Р.Д., Смит Р.С. Современная экономика труда. — М.: 1996, 317 тал

ижил нөхцөлд ижил орлого авчирдаг. Хүмүүн капиталын хувьд ингэж үзэж болохгүй, яагаад гэвэл нэг дээд сургуульд ижил мэргэжил эзэмшсэн хоёр хүн (*хөрөнгө оруулалт адил*) адилхан ажлын байран дээр ажиллахад үр өгөөж нь өөр өөр байдаг нь тухайн хүний төрөлхийн авъяас чадвар, хувийн шинж чанараас шалтгаалдаг билээ.

Хүмүүн капиталын онолын ач холбогдол нь боловсрол, эрүүл мэнд, соёл, шинжлэх ухаан зэрэг “*материаллаг бус*” гэж үздэг байсан салбарыг хөгжлийн ач холбогдлын хувьд бодит үйлдвэрлэлийн салбартай нэг түвшинд аваачиж тавьсанд оршдог билээ.

Хувь хүн мэдлэг боловсрол, соёлын түвшингээ дээшлүүлэх, эрүүл мэндээ сайжруулахад зарцуулсан бүх зардал, үүнээс улбаалагдсан түүний оюун санааны хөгжил нь өөрөө үнэт зүйлийн хувьд хүмүүн капиталыг бүрдүүлж, илүү үр ашигтайгаар эргэж ирдэг ажгуу.

2. Хүмүүн капитал нь үндэсний баялгийн үндсэн хэсэг болох нь

“Улс төрийн арифметик”-ийг үндэслэгч хэмээн нэрлэгддэг У.Пэтти анх удаа “*хүн амын үнэ цэн*”-ийг тоолох гэсэн оролдлого хийсэн бөгөөд тэрбээр бичихдээ: “*харьцангуй, дээд зэргийн гэх мэт үгээр илэрхийлэхийн оронд өөрийн санааг тоо, жин, хэмжигдэхүүнээр илэрхийлэхийг зорьсон*” гэжээ.

Дэлхийн банкны мэргэжилтнүүд үндэсний баялгийн талаар өргөн хүрээтэй санал дэвшүүлж, “Үндэсний баялаг бол нөхөн үйлдвэрлэлийн, байгалийн, хүмүүн гэсэн гурван капиталын нийлбэр” гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, “хувь хүнд чиглэсэн хөрөнгө оруулалт” (*хүнийг өсгөн бойжуулах, сурч боловсрох, мэргэжил эзэмших, өөрийгөө хөгжүүлэх гэх мэт зардал*)-ыг хүмүүн капиталд төдийгүй үндэсний баялагт нэмж тооцох болсноор шинэлэг юм.

Дэлхийн зарим орнуудын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий дундаж хэмжээг Хүснэгт 1-д харуулав.

Дэлхийн нэг хүнд ногдох (ДНБ)-ий дундаж хэмжээ 2015 онд өмнөх оныхоос 9.1 хувиар буурч, 9,995.6 ам.доллар болсон бөгөөд умард хөрш ОХУ-ын нэг хүнд ногдох ДНБ 2010 онтой харьцуулахад 9.2 хувиар буурч, дэлхийн түвшингийн 90 хувь, өмнөд хөрш БНХАУ-ынх дэлхийн түвшингийн 80 хувь, Монголынх 40 хувьтай тэнцүү байна.

Нэг хүнд ногдох ДНБ-ий дэлхийн дундажтай харьцуулж үзэхэд, Монгол улсын дараа хуучин социалист орнуудаас Албани (39.7 хувь), Вьетнам (21.1 хувь), Лаос (18.1 хувь), Камбож (11.6 хувь) орж, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудаас Гүрж (38.0 хувь), Армен (35.0 хувь), Украин (21.2 хувь),

Узбекистан (21.3 хувь), Молдав (18.4 хувь), Киргиз (11.0 хувь), Тажикстан (9.2 хувь) улс жагсаж байгаа ажээ.

Эдгээр орноос сүүлийн 6 жил буюу 2010-2015 онд нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлтөөр Монгол улс 198.7 хувиар тэргүүлж, БНХАУ 184.3 хувь, Туркмен 170.7 хувиар удаалж байна. Харин нэг хүнд ногдох ДНБ-ий 2010-2015 оны бууралтаар Хорват –16.0 хувь, Словени –15.6 хувь, Серби –12.1 хувь, Чех, Босни улс тус тус –10.3 хувиар сүүл мушгиж байгаа ажээ.

Хүснэгт 1

Дэлхийн зарим орнуудын нэг хүнд ногдох (ДНБ)-ий дундаж хэмжээ, ам.доллар

№	Улс орны нэр	2010	2011	2012	2013	2014	2015	2016	Өсөлт+, бууралт-, 2015/2010 %	Дэлхийн дундаж- тай харьцуулсан, %
1.	АНУ	48,950	50,450	52,540	54,070	55,200	55,836.8		+14.1	558.6
2.	ОХУ	9,980	10,820	12,730	13,810	13,210	9,057.1		-9.2	90.6
3.	БНХАУ	4,300	5,000	5,870	6,740	7,380	7,924.7		+84.3	79.3
4.	Монгол	2,000	2,610	3,690	4,390	4,320	3,973.4		+98.7	39.8
Хуучин социалист орнууд										
5.	Польш	12,630	12,840	13,190	13,440	13,730	12,494.5		-1.1	125.0
6.	Чех	19,210	19,380	19,280	18,970	...	17,231.3		-10.3	172.4
7.	Словак	17,130	17,430	17,400	17,810	...	15,962.6		-6.8	159.7
8.	Унгар	13,050	13,020	12,830	13,260	13,470	12,259.1		-6.1	122.6
9.	Серб, Черногори	5,850	5,910	5,700	6,050	5,820	5,143.9		-12.1	51.5
10.	Хорват	13,740	14,050	13,460	13,470	13,020	11,535.8		-16.0	115.4
11.	Босни	4,680	4,680	4,600	4,780	4,770	4,197.8		-10.3	42.0
12.	Словен	24,540	24,560	23,290	23,220	...	20,713.1		-15.6	207.2
13.	Македон	4,630	4,730	4,680	4,900	5,070	4,852.7		+04.8	48.5
14.	Румын	8,430	8,520	8,570	9,050	9,370	8,972.9		+06.4	89.8
15.	Болгар	6,630	6,870	7,070	7,280	7,420	6,819.9		+02.9	68.2
16.	Албани	4,360	4,390	4,370	4,510	4,460	3,965.0		-9.1	39.7
17.	Вьетнам	1,270	1,390	1,560	1,740	1,890	2,111.1		+66.2	21.1
18.	Камбож	740	810	880	950	1,010	1,158.7		+56.6	11.6

19. Лаос	980	1,090	1,270	1,450	1,600	1,812.3	+84.9	18.1
20. Куба*	5,590	5,910	+05.7	59.1
Балти орчмын орнууд								
20. Литва	12,350	13,020	13,940	15,100	15,380	14,172.2	+14.8	141.8
21. Латви	12,720	13,090	13,910	15,280	15,660	13,664.9	+07.4	136.7
22. Эстони	14,570	15,830	16,800	17,970	18,530	17,295.4	+18.7	173.0
Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд								
23. Украйн	2,990	3,110	3,500	3,760	3,560	2,115.0	-29.3	21.2
24. Беларусь	5,990	6,130	6,400	6,780	7,340	5,740.5	-4.2	57.4
25. Молдав	1,820	1,980	2,150	2,470	2,550	1,843.2	+01.3	18.4
26. Гүрж	2,680	2,850	3,290	3,560	3,720	3,796.0	+41.6	38.0
27. Армен	3,370	3,430	3,700	3,800	3,810	3,499.8	+03.9	35.0
28. Азербайджан	5,370	5,530	6,290	7,350	7,590	5,496.3	+02.4	55.0
29. Казахстан	7,440	8,190	9,780	11,560	11,670	10,508.4	+41.2	105.1
30. Узбекистан	1,300	1,510	1,703	1,940	2,090	2,132.1	+64.0	21.3
31. Киргиз	850	880	1,040	1,220	1,250	1,103.2	+29.8	11.0
32. Туркмен	4,070	4,660	5,410	6,880	8,020	6,947.8	+70.7	69.5
33. Таджикистан	730	780	880	990	1,060	925.9	+26.8	9.2
Нийт дэлхий	9382.0	9844.7	10427.4	10792.3	10857.8	9,995.6	+6.5	100.0

Тайлбар: * 2015 оны мэдээлэл байхгүй тул мэдээлэлгүй сүүлийн оноор тооцов.

Эх сурвалж: data.worldbank.org/indicator/NY.GNP.PCAP.CD

Оросын эрдэмтэн С.Валентей, Л.Нестеров нарын тооцоноор хүн төрөлхтөн 550 их наяд ам.доллар (дунджаар нэг хүнд 90 мянган ам.доллар)-ын хөрөнгө хуримтлуулжээ. Их долоогийн орнуудад нэг хүнд 300-400 мянган ам.доллар ногдож, дэлхийн дундаж түвшнээс 3.3-4.4 дахин өндөр байна.

Хүснэгт 2

Зарим орнуудын үндэсний баялгийн хэмжээ, ХХ зууны эцэст

Улс орнууд	Нийт хэмжээ (их наяд ам. доллар)	Нэг хүнд ногдох (мян. ам. доллар)	Баялгийн хэлбэр, нийт баялагт эзлэх хувийн жин, %		
			Хүмүүн	Байгалийн	Нөхөн үйлдвэрлэл
Дэлхий	550.0	90.0
АНУ	124.0	460.0	77.0	4.0	19.0
ОХУ	59.0	400.0	50.0	40.0	10.0
Япон	54.0	420.0	68.0	1.0	31.0
БНХАУ	35.0	28.0	77.0	7.0	16.0
ХБНГУ	31.0	375.0	75.0	1.0	23.0
ИБУИНВУ	21.0	353.0	79.0	2.0	19.0
Франц	21.0	360.0	74.0	3.0	23.0
Итали	17.0	295.0	73.0	12.0	13.0
Энэтхэг	12.0	20.0	58.0	20.0	22.0
Канад	6.0	300.0	69.0	11.0	20.0
Австрали	6.0	320.0	66.0	12.0	23.0
Саудын Араб	3.5	170.0	40.0	42.0	18.0
Венесуэл	2.6	110.0	49.0	7.0	44.0
Чили	2.3	150.0	79.0	10.0	12.0
Финлянд	1.6	320.0	56.0	7.0	37.0
Норвег	1.3	300.0	57.0	10.0	33.0
Шинэ Зеланд	1.0	280.0	59.0	18.0	23.0
<i>17 орны дүн</i>	400.0	130.0	65.0	13.0	22.0

Эх сурвалж: Дэлхийн банкны шинжээчдийн дүгнэлтийг оросын эрдэмтдийн дүгнэлтээр баяжуулав.

Хэрэв нийт баялагт эзлэх хувийн жинг үзүүлбэл: АНУ-д хүмүүн капитал нь нийт баялгийн 77 хувь, байгалийн баялаг нь 4 хувийг эзэлж байхад, ОХУ-д

хүмүүн капитал нь 50 хувь, байгалийн баялаг нь 40 хувь, БНХАУ-д хүмүүн капитал нь 77 хувь, байгалийн баялаг нь 7 хувийг тус тус эзэлж байна.

НҮБ-ын шинжээч, эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар нийгмийн тогтвортой хөгжлийн гол хүчин зүйл нь хүний хөгжил, мөн хүмүүн капиталын хэмжээ, чанар байдаг ажээ.

Иймээс төр засаг, хувийн хэвшлийнхэн хувь хүнд оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх хэтийн зорилт байх учиртай. Нийгмийн баялгийн бүтцэд хүмүүн капиталын эзлэх хувийн жингийн зохистой өсөлтийг хангасан тохиолдолд л бодит хуримтлал бий болно.

Хүмүүн капиталын хуримтлалд үнэлгээ өгөх зардлын ба орлогын (ашгийн) гэсэн үндсэн хоёр арга байдаг. Зардлын аргаар хүмүүн капиталын энгийн хэлбэр болох боловсрол олгох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг нийгмээс болон хувь хүн, түүний гэр бүл, эцэг, эхээс гарч буй нийт зардлын нийлбэрийг тооцдог.

Хүснэгт 3

Монгол Улсын хүний хөгжлийн индекс, улс, нийслэлээр

Зорилт/Шалгуур үзүүлэлт		1990						2015	
		2000	2011*	2012*	2013*	2014*	Гүй-цэтгэл	Зорилт	
ХХИ	улс	–	0.667	0.723	0.718	0.726	0.735	0.735	0.830
	нийслэл	–	0.707	0.794	0.808	0.813	0.818		

Тайлбар: * Нөөц ашиглалтын 2011-2015 оны үр дүнгээр тодотгосон.

Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газар. Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. Үндэсний тав дахь илтгэл – 2013. (142т).

ҮСХ. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл – 2015-2016. (142т).

Монгол Улсын хүний хөгжлийн индекс (ХХИ) сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өссөөр байгаа учраас манай орон хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудын тоонд 2015 оноос орсон боловч бусад хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудтай харьцуулахад нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (ҮНО)-ын хэмжээ харьцангуй бага байгаа билээ.

Манай орны ХХИ-ийг хөрш хоёр орны болон дэлхийн дундаж ХХИ-тэй харьцуулан авч үзье.

Хүснэгт 4-өөс үзэхэд, ХХИ-ээр умард хөрш ОХУ дэлхийд 49-д жагсаж, хүний хөгжлийн нэн өндөр түвшинтэй орнуудын эгнээнд анх удаа орж, өмнөд хөрш БНХАУ 90 дүгээрт, Монгол Улс 92 дугаарт жагсаад хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнуудын эгнээнд багтаж байгаа ажээ.

Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хүний хөгжлийн индекс

Тухайн орны ХХИ-ийн эрэмбэ	Хүний хөгжлийн индекс ХХИ 2015	Төрөлтөөс тооцсон дундаж нас (жилээр) 2015	Сургалтын хүлээгдэж буй хугацаа (жилээр) 2015	Сургалтын дундаж хугацаа (жилээр) 2015	Нэг хүнд ногдох ҮНО (худалдан авах чадварын 2011 оны паритетээр, ам.доллар) 2015	Нэг хүнд ногдох ҮНО-ын эрэмбэнээс ХХИ-ийн эрэмбийг хасах нь 2015	ХХИ-ийн эрэмбэ 2014
<i>Хүний хөгжлийн нэн өндөр түвшинтэй орнууд</i>							
49 ОХУ	0.804	70.3	15.0	12.0	23 286	1	50
<i>Хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд</i>							
90 БНХАУ	0.738	76.0	13.5	7.6	13 345	-7	92
92 Монгол	0.735	69.8	14.8	9.8	10 499	4	92
Хүний хөгжлийн нэн өндөр түвшинтэй орнууд	0.892	79.4	16.4	12.2	39 605	-	-
Хүний хөгжлийн өндөр түвшинтэй орнууд	0.746	75.5	13.8	8.1	13 844	-	-
Хүний хөгжлийн дунд түвшинтэй орнууд	0.631	68.6	11.5	6.6	6 281	-	-
Хүний хөгжлийн бага түвшинтэй орнууд	0.497	59.3	9.3	4.6	2 649	-	-
Нийт дэлхий	0.717	71.6	12.3	8.3	14 447	-	-

Эх сурвалж: НҮБХХ. Хүний хөгжлийн илтгэл – 2016-2017. (198-201т).

Дэлхийн хүний хөгжлийн 2016 оны илтгэлд дурдсанаар манай орны нэг хүнд ногдох ҮНО 2015 онд 10,449 ам.доллар байсан бол ОХУ-д 23,286 ам.доллар, БНХАУ-д 13,345 ам.доллар байгаа нь манай орныхоос даруй 2.2 ба 1.3 дахин их бөгөөд манай орны хүн амын амьжиргааны түвшин хөрш хоёр орныхоос нэлээд бага байгааг харуулж байна. Нэг хүнд ногдох ҮНО-ын дэлхийн дундаж хэмжээ 14,447 ам.доллар байгаа бөгөөд умард хөрш ОХУ-д нэг хүнд ногдох ҮНО дэлхийн дунджаас 1.6 дахин их, өмнөд хөрш БНХАУ-д дэлхийн дунджийн 92 хувь, манай оронд 72 хувьтай тэнцүү байна.

БНХАУ-д төрөлтөөс тооцсон дундаж наслалт 76 жил байгаа нь Монгол Улс, ОХУ-ынхаас ойролцоогоор 6 жилээр илүү бөгөөд БНХАУ-ын хүн амын эрүүл мэнд илүү сайн түвшинд байгааг харуулж байна. Харин ОХУ-д дундаж наслалт манай орныхоос тун ялимгүй их байгаа нь Афганистан, Чечений дайн, хөдөө орон нутаг дахь архидалтын улмаас орос эрэгтэйчүүдийн дундаж наслалт багассантай холбоотой гэж зарим судлаачид үздэг.

Харин сургалтын хүлээгдэж буй хугацаа Монгол Улсад 14.8 жил, ОХУ-д 15 жил, харин БНХАУ-д 13.5 жил байгаа нь манай орны хүн амын боловсролын түвшин харьцангуй сайн байгааг харуулж байна.

ХХИ-ийг бүс, аймаг, нийслэлээр харьцуулан авч үзье.

Хүснэгт 5-аас харахад, манай орны хүн амын дундаж наслалтын индекс харьцангуй өндөр хэмжээнд, хүн амын боловсролын түвшний индекс хэвийн хэмжээнд, харин нэг хүнд ногдох ҮНО-ын индекс доогуур хэмжээнд байна.

ХХИ 2015 онд урьд оны түвшинд буюу 0.735 байсан бол Зүүн бүсэд 0.004 нэгжээр буурч, нийслэлд 0.004 нэгж, бусад бүсэд 0.001-0.002 нэгжээр тус тус өсчээ. Харин хүн амын боловсролын түвшний индекс улсын хэмжээнд болон Завхан, Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр, Дундговь, Төв, Сүхбаатар аймгаас бусад аймагт буурсан нь зүй ёсоор анхаарал татаж байна. Хүн амын боловсролын түвшний индекс 2013 онд буурсан хэдий ч 2014 онд 0.013 нэгжээр өссөн байтлаа яагаад 2015 онд 0.005 нэгжээр буурах болов? гэдгийг онцгойлон судлах шаардлагатай байна.

Бүс нутгаар авч үзэхэд, Зүүн, Хангайн бүсэд дундаж наслалт, боловсролын түвшин доогуур, нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ нь Баруун, Хангайн бүсэд харьцангуй доогуур байна. ХХИ бүх бүсэд улсын дунджаас доогуур, харин нийслэл, Орхон, Говьсүмбэр аймагт улсын дунджаас дээгүүр байгаа ажээ. Цаашид улсын төсвийн төлөвлөлтийн үед аймаг бүрийн ХХИ-ийг бүсийнхтэй харьцуулан харгалзан үзэж төсвийн төсөлд тусгаж байх нь зүйтэй юм.

Хүснэгт 5

Монгол Улсын хүний хөгжлийн индекс, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг	Хүн амын дундаж наслалтын индекс					Хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс					Нэг хүнд ногдох УНО-ын индекс					Хүний хөгжлийн индекс (ХХИ)				
	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016	2012	2013	2014	2015	2016
Бүгд	0.749	0.756	0.763	0.768	0.726	0.724	0.737	0.732	0.682	0.701	0.708	0.708	0.718	0.726	0.735	0.735	0.718	0.726	0.735	0.735
Баруун бүс	0.756	0.763	0.772	0.780	0.626	0.619	0.618	0.611	0.559	0.597	0.617	0.620	0.642	0.656	0.665	0.666	0.642	0.656	0.665	0.666
Баян-Өлгий	0.796	0.803	0.812	0.820	0.609	0.606	0.602	0.586	0.531	0.565	0.586	0.589	0.636	0.650	0.659	0.657	0.636	0.650	0.659	0.657
Говь-Алтай	0.736	0.743	0.751	0.760	0.629	0.616	0.615	0.602	0.556	0.594	0.625	0.630	0.636	0.648	0.661	0.660	0.636	0.648	0.661	0.660
Завхан	0.742	0.748	0.757	0.765	0.616	0.616	0.615	0.620	0.591	0.630	0.644	0.646	0.647	0.662	0.669	0.674	0.647	0.662	0.669	0.674
Увс	0.728	0.734	0.743	0.751	0.611	0.605	0.602	0.589	0.564	0.599	0.622	0.622	0.631	0.643	0.653	0.650	0.631	0.643	0.653	0.650
Ховд	0.780	0.786	0.796	0.804	0.662	0.654	0.658	0.658	0.553	0.601	0.614	0.620	0.659	0.676	0.685	0.689	0.659	0.676	0.685	0.689
Хангайн бүс	0.746	0.754	0.763	0.772	0.663	0.662	0.665	0.603	0.647	0.670	0.676	0.677	0.664	0.674	0.679	0.680	0.664	0.674	0.679	0.680
Архангай	0.762	0.769	0.777	0.786	0.601	0.596	0.581	0.586	0.591	0.622	0.630	0.633	0.647	0.658	0.658	0.663	0.647	0.658	0.658	0.663
Баянхонгор	0.737	0.743	0.752	0.760	0.589	0.584	0.589	0.585	0.565	0.607	0.628	0.631	0.626	0.641	0.653	0.655	0.626	0.641	0.653	0.655
Булган	0.789	0.795	0.805	0.813	0.566	0.563	0.559	0.562	0.614	0.659	0.662	0.661	0.649	0.666	0.668	0.671	0.649	0.666	0.668	0.671
Орхон	0.767	0.773	0.782	0.790	0.731	0.743	0.762	0.729	0.806	0.809	0.809	0.808	0.767	0.774	0.784	0.775	0.767	0.774	0.784	0.775
Өвөрхангай	0.744	0.750	0.759	0.767	0.567	0.563	0.564	0.569	0.534	0.591	0.608	0.609	0.608	0.630	0.638	0.643	0.608	0.630	0.638	0.643
Хөвсгөл	0.678	0.696	0.705	0.712	0.588	0.582	0.594	0.584	0.564	0.597	0.610	0.613	0.608	0.623	0.634	0.634	0.608	0.623	0.634	0.634
Төвийн бүс	0.776	0.782	0.791	0.800	0.649	0.642	0.646	0.643	0.627	0.654	0.658	0.657	0.681	0.690	0.695	0.697	0.681	0.690	0.695	0.697
Говьсүмбэр	0.797	0.804	0.813	0.822	0.689	0.693	0.698	0.710	0.586	0.632	0.650	0.649	0.685	0.706	0.718	0.723	0.685	0.706	0.718	0.723
Дархан-Уул	0.731	0.738	0.746	0.754	0.845	0.822	0.817	0.788	0.574	0.595	0.611	0.616	0.708	0.712	0.720	0.715	0.708	0.712	0.720	0.715
Дорноговь	0.757	0.763	0.772	0.780	0.639	0.638	0.641	0.639	0.632	0.649	0.656	0.645	0.674	0.681	0.687	0.685	0.674	0.681	0.687	0.685
Дундговь	0.803	0.809	0.819	0.827	0.547	0.541	0.548	0.551	0.603	0.661	0.666	0.666	0.642	0.661	0.669	0.672	0.642	0.661	0.669	0.672
Өмнөговь	0.776	0.782	0.791	0.800	0.612	0.604	0.624	0.610	0.688	0.715	0.668	0.664	0.689	0.697	0.691	0.687	0.689	0.697	0.691	0.687
Сэлэнгэ	0.782	0.789	0.798	0.806	0.615	0.612	0.619	0.619	0.649	0.660	0.676	0.675	0.679	0.683	0.694	0.696	0.679	0.683	0.694	0.696
Төв	0.785	0.792	0.801	0.809	0.574	0.580	0.574	0.582	0.603	0.646	0.671	0.675	0.648	0.667	0.675	0.683	0.648	0.667	0.675	0.683
Зүүн бүс	0.751	0.766	0.775	0.783	0.602	0.600	0.605	0.604	0.621	0.665	0.703	0.689	0.655	0.674	0.691	0.688	0.655	0.674	0.691	0.688
Дорнод	0.704	0.736	0.745	0.753	0.651	0.643	0.654	0.649	0.615	0.678	0.749	0.719	0.656	0.685	0.715	0.706	0.656	0.685	0.715	0.706
Сүхбаатар	0.781	0.787	0.797	0.805	0.570	0.561	0.567	0.572	0.653	0.675	0.689	0.687	0.662	0.668	0.678	0.681	0.662	0.668	0.678	0.681
Хэнтий	0.768	0.775	0.784	0.792	0.586	0.595	0.593	0.592	0.596	0.641	0.646	0.651	0.645	0.666	0.669	0.673	0.645	0.666	0.669	0.673
Улаанбаатар	0.773	0.779	0.788	0.797	0.866	0.865	0.870	0.870	0.750	0.758	0.768	0.773	0.795	0.800	0.808	0.812	0.795	0.800	0.808	0.812

Тайлбар: * Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн “Олон улсын эрэгцүүлэлтийн хөтөлбөр-2011”-ийн хүрээнд улс орнуудын худалдан авах чадварын паригетийг шинэчлэн тооцсон учир 2012-2014 оны гүйцэтгэл өөрчлөгдсөн ажээ

Эх сурвалж: УСХ, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл – 2015-2016. (141т).

Хүмүүн капиталын өртөг нь хувь хүний амьдралын бүхэл үеийн туршид түүнийг хөгжүүлэхэд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын үр дүнгээр тодорхойлогддог.

Хувь хүнийг бага наснаас нь өсгөн бойжуулах, боловсрол, мэдлэг, мэргэжил олгох, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зардлыг оруулаад нэг хүнийг эдийн засгийн үйл ажиллагаанд буюу нөхөн үйлдвэрлэлд оруулахад ОХУ-д дунджаар 280 мянган ам.долларын зардал гардаг атал АНУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны тооцоогоор америкийн дундаж гэр бүл 2014 онд нэг хүүхдийг 18 нас хүртэл өсгөн хүмүүжүүлэхэд 235 мянган ам.доллар зарах бөгөөд хэрэв дээд сургууль, коллежид сургана гэвэл энэ зардлыг хоёр дахин өсгөх хэрэгтэй ажээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дээд хэмжээний уулзалт болон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган 2015 оны 9 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо болж, НҮБ-ын гишүүн 193 улс тогтвортой хөгжлийн төлөөх хөтөч зургаа тохиролцож, “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030”-ийг баталсан нь дэлхий нийтийн хөгжлийн луужин болсон билээ.

Иймд манай оронд хүмүүн капиталын тоо, хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тооцож, цаашид төрөөс тогтвортой хөгжлийн талаар баримтлах бодлогод тусгах зайлшгүй шаардлага байна гэдгийг төр засгийн удирдлага анхааралдаа авна гэж найдаж байна.

Ном зүй:

- [1] Критский М. М. (1991). Человеческий капитал. (65х), Ленинград.
- [2] Монгол Улсын Засгийн газар (2013). Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт. *Үндэсний тав дахь илтгэл*.
- [3] Пэтти У. (1940). Экономические и статистические работы. Москва.
- [4] Рикардо Д. (1955). Сочинения. Б.1. (183х), Москва.
- [5] Смит А. (1962). Исследование о природе и причинах богатства народов (*An Inquiry into the Nature and Causes of the Wealth of Nations*). Москва, Соцэкгиз.
- [6] ҮСХ (2015, 2016). Монгол Улсын Статистикийн эмхэтгэл.
- [7] ҮСХ (2016, 2017). Монгол Улсын Статистикийн эмхэтгэл.
- [8] Фишер С., Дорнбуш Р., Шпалензи Р. (1993). Экономика. (303х), Москва.
- [9] Эренберг Р.Д., Смит Р.С. (1996). Современная экономика труда. (317х), Москва.
- [10] Bowen H. R. (1978). Investment in Learning. (362х), San Francisco.
- [11] World Bank. URL: data.worldbank.org/indicator/NY.GNP.PCAP.CD